



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/299

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлт"-ийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БНХАУ-ын ШУӨЗО-ы Урумчи хотод эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аж үйлдвэр, бүтээн байгуулалттай танилцах, туршлага судлах арга хэмжээнд шаардагдах зардлыг баталсугай.

2. "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлт"-ийн бодлогын аж үйлдвэржилт болон хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР